

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтын “4.1.11” гэснийг “12.8” гэж, 38 дугаар зүйлийн 38.7. дахь хэсгийн “нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.1-д” гэснийг Татварын ерөнхий хуульд” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

**МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Мэргэжлийн нэгдсэн холбоодын эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 8 дугаар зүйлийн 8.5, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.1-д” гэснийг “Татварын ерөнхий хуульд” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нотариатын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8, 21 дүгээр зүйлийн 21.2.12 дахь заалтад заасан “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.21-д” гэснийг “Татварын ерөнхий хуулийн 6.1.53-т” гэж, 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.14-т” гэснийг “Татварын ерөнхий хуулийн 6.1.58-д” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

ХОТЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хотын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай[5] хуулийн 10.2-т заасан журмын дагуу” гэснийг “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасны дагуу” гэж, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд” гэснийг “Татварын ерөнхий хуульд” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг